

Улс төрийн намыг санхүүжилт ба хандивлагчид

МУИС-ийн Социологийн тэнхмийн багш Ч.Тамир

Өнөөдөр манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа улс төрийн намууд сонгуулийн кампанийн зардлаа хэрхэн санхүүжүүлж буй бодит нөхцөл байдал¹ дээр тулгуурлан түүнээс үүдсэн нийгмийн үр дагавар, ялангуяа сөрөг асуудлыг энэхүү илтгэлээрээ хөндөн гаргахыг оролдлоо.

Манай улсад үйл ажиллагаа явуулж буй бүхий л нам хатуу гишүүнчлэлтэй, чанга хэв маягт хамаарна. Ийм намууд нь орон нутагт бүхэлдээ тархсан салбартай, байнгын аппарат ажиллуулах шаардлагатай байдаг учир байнга санхүүгийн /мөнгөний/ бэрхшээлтэй тулгардаг байна. Намууд санхүүжилт олох нэлээд хэдэн хувилбар байдгийг дурдвал гишүүдийн татвар, төрийн дэмжлэг, хандив авах гэсэн гурван үндсэн хэлбэртэй байна. Эхний хэлбэрийн хувьд намын гишүүдийн татвар нь намын орлогын үндсэн эх үүсвэр болох ёстой боловч өнөөгийн байдлаар энэ нь намуудын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд хангалтгүй юм. Үүнийг хүн амын орлого бага байгаа тул намын гишүүдээсээ татвар авч чаддаггүй, ихэнх намын хувьд татвар авах механизм нь зүгшрээгүй, намын гишүүд нь татвар өгч хэвшээгүй зэрэгтэй холбон тайлбарлаж болох талтай. Харин хоёр дахь хэлбэрийн хувьд зөвхөн парламентад суудалтай нам л улсын төсвөөс мөнгө авдаг жишигтэй. Тийм учраас өнөөгийн улс төрийн намуудын санхүүгийн эх үүсвэр нь ихэвчлэн бизнесийн салбарын хандиваас бүрддэг бөгөөд тэр хэрээрээ хандивлагчид намуудад гүнзгий нөлөөтэй байдаг байна.

Өнөөдөр манай улсад үйлчилж байгаа Улс төрийн намуудын тухай хууль, Сонгуулийн тухай хууль зэрэг холбогдох эрх зүйн актанд анализ хийж үзвэл улс төрийн намын санхүүжилтийн талаар нарийн зохицуулалт үгүйлэгдэж байгаа нь харагдана. Ялангуяа санхүүжилт хийх эх сурвалж, тэдгээрийн нарийн зааг ялгаа, цаашилбал хандивийн хэмжээ, зэргийг зааж өгөөгүй, мөн хуулийн зарим нэг заалтыг биелүүлэх субъектийг нарийвчлан тодорхойлоогүй, хэлбэр төдий шинж чанартай заалтууд багагүй байгаа нь эл саналыг дэвшүүлэхэд хүрч байна. Чухамдаа тийм ч учраас улс төрийн намын санхүүжилтийн асуудал хаалттай сэдэв байсаар ирлээ.

Хандивлагчид улс төрийн намын үйл ажиллагааг санхүүжүүлэхдээ эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс, шуудхан хэлэхэд авилгалын шинжтэй сэдлээр хандах явдал тохиолдож байсан нь нууц биш юм. Өнөөдөр улс төрчдийн хувьд ч гэсэн хандивлагчдын эл хэт эдийн засгийн ашиг сонирхлыг саармагжуулах арга хэмжээ авч чадахгүй, тодорхой бүлэглэлийн гар хөл болох, зарим тохиолдолд тэдний эрх ашгийг улайм цайм илэрхийлэх, цаашилбал улс төрчид барьцаалагдах явдал гарч байв. Үүнээс улбаалан улс төрийн зөв шийдвэр гаргаж чадахгүй байх, хандивлагчдад барьцаалагдах, улс төрийн зарим шийдвэрээс болж эдийн засгийн бүлэглэлүүдийн хоорондох зөрчил хурцдаж үүнийг нь улс төрчид ба намууд үүрэх, чухамдаа үүнтэй холбоотой Засгийн газар огцроход хүрэх зэрэг зохисгүй явдал ажиглагдаж

¹Ч.Тамир. «Монголын нийгэм дэх улс төр, бизнесийн харилцааны зарим асуудалд» //Шинэ толь № 43. УТБА-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл

байлаа. Аль ч Засгийн газрын үед эл зөрчил нь төрийн хямралд хүргэж болзошгүй байгааг анхааран нухацтай судлах шаардлагатай юм. Нийгэмд тархмал шинжтэй байгаа эл үзэгдэл 2004 оны парламентын сонгуульд ч дахин давтагдахгүй гэсэн баталгаа алга байна.

Тиймээс улс төрийн намын санхүүжилтыг зохицуулах хэрэгцээ шаардлагыг дараахь байдлаар тодорхойлж болохоор байна.

Нэг. Улс төрийн тэгш байдал алдагдах буюу мөнгөний улс төр болж байгаа тухай.

Судалгаанаас үзэхэд дэлхий нийтэд сонгуульд зарцуулах мөнгөний хэмжээ асар хурдан өссөөр байна. Энэ нь манай оронд ч гэсэн ажиглагдаж байгаа төдийгүй сөрөг нөлөөтэй байна. Ингэж сонгуулийн зардал өссөнийг шууд муу зүйл гэж нэгэн утгаар тодорхойлж болохгүй мөртлөө манай оронд эл үзэгдэл сөрөг нөлөөтэй байгаад дараах тайлбарыг хийж болох юм. Юуны өмнө дэлхийн бусад оронд улс төрчид ба бизнес эрхлэгчдийн хооронд заагтай байдаг бол манайд холилдох, сүүлдээ нэгээр нөгөөг нь хийх гэсэн сөрөг хандлага төлөвшжээ. Үүнийг улс төрч хүн нөлөөгөө ашиглан бизнес хийж мөнгөтэй болох, бизнесмен хүн улс төр хийж мөнгөө өсгөх гэсэн үзэгдлээс харж болно. Тодорхой утгаараа манай нийгэм жижиг нийгэм юм. Судалгаанаас үзэхэд Монголд идэвхтэй улс төр хийж байдаг цөөхөн хүн байдаг бол бизнесийн үйл ажиллагаа явуулдаг мөн л түүнээс цөөхөн хүмүүс бий. Эдгээр нь өөр хоорондоо найз нөхөд, ах дүү, нэг анги, нутаг ус зэрэг нийтлэгийн харилцаагаар нягт холбогдсон, бараг бүгд Улаанбаатар хотод амьдардаг хүмүүс юм. Улс төрчид ба бизнесменүүдийн ийм ойр байдал нь улс төрийн харилцаан дахь тэгш байдлыг эдийн засгийн харилцааны тэгш бус байдал тодорхойлоход хүргэж, эдийн засгийн харилцааг тодорхойлогч шинжтэй болгох бөгөөд улс төрийн тэгш байдал үгүй болж байна. Учир нь иргэд эдийн засгийн чадавхийн хувьд янз бүрийн байдалтай байж болно. Энэ бол зах зээлийн эдийн засагтай ардчилсан нийгэмд хэвийн үзэгдэл юм. Харин улс төрийн хувьд тэгш эрхтэй байх нь ардчиллын хамгийн чухал зүйлд тооцогдох юм.

Удаахь шалтгаан нь манай улс төрчид ба намууд нь хандивлагчдаас тодорхой төвшинд өөрийгөө хамгаалах чадвар бүрэлдээгүй байгаа явдал юм. Үүнд аль болох олон хандивлагчаас бага мөнгө авч аль нэгэнд давуу байдал үүсгэхгүй байх, нам өөрийн үйл ажиллагааны менеджментээр зардлаа нөхөх, санхүүжилтад иргэдийг олноор татан оролцуулах зэрэг олон төрлийн арга хэмжээ авч болох билээ.

Чухамдаа манай орны дурдсан өвөрмөц нөхцөл нь сонгуульд өрсөлдөхөд зарцуулах мөнгөний хэмжээ хэт өсгөж, улс төрийн тэгш байдал алдагдахад хүргэж байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Хоёрт. Улс төрийн намын санхүүжилтийн асуудал нь авилгалын үр дагаврыг бий болгож байна. Гэхдээ нийгэмд байгаа авилгал нь улс төрийн намуудын санхүүжилтад нөлөө үзүүлээд байна уу, эсвэл улс төрийн намын санхүүжилт нь цаагуураа авилгал бий болгох нөхцлийг бүрдүүлээд байна уу гэсэн асуултад бид хариулах ёстой юм. Хэрвээ нийгэмд оршин байгаа

авилгалын асуудал нь уг асуудалд нөлөөлөөд байна гэж таамаглавал бидний хөндсөн сэдэв туйлын ээдрээтэй асуудал гэдгийг харж болно. Учир нь авилгалын асуудалтай бид тэмцээд өнөөг хүртэл аль ч Засгийн газар амжилт олж чадаагүй байна. Ямар болов ч эдгээр нь хоорондоо нарийн уялдаатай бие биеэ нөхцөлдүүлдэг системт шинжтэй хүчин зүйл гэдэг нь мэдэгдэж байна.

Гуравт. Төр иргэдэд үйлчлэх үүргээ умартахад хүрч байна.

Монгол дахь улс төрийн намуудын санхүүжилтийн өнөөгийн нөхцөл байдал нь төрийн олон түмэнд үйлчлэх үүргээ умартахад хүргэж, улс төр, эдийн засгийн явцуу бүлэглэлийн эрх ашгийг төлөөлөхөд хүргэж байна. Сонгуулиар ялсан намын бодлого сонгуульд тэднийг дэмжиж байсан хандивлагчдад ямар нэгэн байдлаар ашигтай байдаг эл үзэгдэл зөвхөн манай оронд ч бус бусад олон оронд түгээмэл ажиглагддаг гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Монголд үйлчилж байгаа намын санхүүжилтийн схем нь судлаачдын дунд төдийлөн яригддаггүй, олон түмэн болон улс төр, эдийн засгийн бүлэглэлийн эрх ашгийн зөрчилдөөний асуудлыг үүсгэдэг. Үүнийг онолын төвшинд төр болон иргэдийн харилцааны зөрчил гэж томъёолсон ч болно. Учир нь манай үе үеийн төр, засгийн газруудаас явуулж байгаа бодлогыг системтэй шинжлэн үзвэл иргэдийн эрх ашгийг илэрхийлэхээс илүүтэй улс төр, бизнесийн явцуу бүлэглэлүүдийн эрх ашгийг илэрхийлж байна уу даа гэсэн сэтгэгдэл төрөхөөр байдаг. Энэ нь цаагуураа өнөө л бидний өгүүлэн буй зүйл болох улс төрийн намын санхүүжилтийн асуудалтай ямар нэгэн сэжмээр холбоотой болж ирэх юм. Ялангуяа хүн амын тоо цөөн, эдийн засгийн баялаг ба зах зээл багатай манай орны хувьд эл зөрчил хэтэрхий хүнд тусдаг гэдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

Дөрөвт. Улс төрийн намуудын санхүүжилтын өнөөгийн нөхцөл байдлын нэгэн шууд үр дагавар бол эдийн засгийн салбарын өрсөлдөөний үнэ цэнэ багасч байгаа явдал юм.

Сонгуульд ялсан намыг дэмжигч тодорхой эдийн засгийн бүлэглэл тендерт шууд ялалт байгуулдаг жишээгээр үүнийг тайлбарлаж болох юм. Энэ бол одоо шууд мэдэгдэхгүй ч цаагуураа манай эдийн засагт, цаашилбал улс орны хөгжилд ноцтой хор хохирол учруулж байдаг сөрөг үр дагавартай зүйл мөн. Учир нь шудрага өрсөлдөөн бол зах зээлийн эдийн засгийн хамгийн гол элемент байдаг билээ. Сонгуульд ялсан намыг дэмжигч бизнес бүлэглэлүүд тендерт шууд ялалт байгуулдаг жишээгээр үүнийг тайлбарлаж болох юм.

Тавд. Иргэдийн улс төрийн оролцоо буурч², сонгогчийн сонгуулийн зан үйл сүүлийн үед өөрчлөгдөж байна.³

Сонгуулийн зардлын өсөлт, түүний зохицуулалтгүй далд байдал нь сонгуулийг мөнгөөр зодож өрсөлдөхөд хүргэх ба энэ нь иргэдийн хувьд тэдний сонгуульд хандах зан үйлийг өөрчлөхөд

² «Монголчуудын улс төрийн оролцоо буурч байна»// Ч.Тамир, Д.Ганхуяг. Өнөөдөр сонин. 2002-8-2

³Ч.Тамир. «Монголчуудын улс төрийн оролцооны өөрчлөлт үнсэн хэв маягууд» илтгэл

МУИС-ийн багш нарын эрдэм шинжилгээний бага хурал 2002-6 сар.

Ч.Тамир. «Монголчуудын улс төрийн оролцоо» илтгэл// Ардчилсан хувьсгалын 12 жилийн ойн эрдэм шинжилгээний бага хурал 2003- 4 сар.

хүргэж буйг та өдөр тутмын амьдралаас харж болно. Тухайлбал, иргэд сонгууль болно гэхээр төрөл бүрийн үйлчилгээ, үнэгүй юм тараах, мөнгө өгөх зэрэг материаллаг талаас харах сонирхол нэгэнтээ бий болсныг хэлэхгүй өнгөрч болохгүй. Энэ нь сонгууль бол иргэд өөрсдийн төрөө барих үйл хэрэгт оролцож байгаа хэрэг, ардчиллын тулгуур үзэл биш, харин ч шуудхан наймаалцаж болохуйц, нэг үгээр тайлбарлаж боломгүй тийм сонин хэлбэртэй ойлголт болгож төлөвшжээ. Цаашдаа энэ хандлага Монголын ардчилалд багагүй сөрөг нөлөө үзүүлэх нь маргаангүй юм.

Эцэст нь тэмдэглэхэд намын санхүүжилтийг тодорхой зохицуулалттай, түүнийг нь хөндлөнгөөс хянадаг байгууллагатай, ил тод болгох юм бол намууд хандивлагчдаас санхүүгийн дэмжлэг авснаар төр иргэн хоёрыг холбох үүргээ илүү сайн гүйцэтгэх бололцоотой болох юм.